

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Суурь түвшин	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хэрэгжилт	Зарцуулсан хөрөнгө	Хэрэгжилтийн үнэлгээ
Зорилго 1: Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх						
1	1.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх;		- Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх	<p>Байгууллагын цахим хуудасны www.uda.ub.gov.mn Хууль эрх зүйн буланд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийг байршуулан олон нийтэд нээлттэй сурталчлан ажиллав. Мөн Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системийн холбоос, болон "Авлигын эсрэг хамтдаа" таныг сонсож байна буланг тогтмол ажиллуулж байна.</p> <p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн систем ERP-д байршуулсан Өөрчлөлтийг хамтдаа аян, Соён гэгээрүүлэх аяны "Авлигын шилэн бөмбөлөг" "Шударга тоглоцгооё", "Чи бол авлигатай тэмцэх газар", "Найзын яриа", "Авлига нь үр хүүхдүүдийн маань гэрэлт ирээдүйг хулгайлдаг", "Авлигатай тэмцэх нь бүх нийтийн үйлс", "Авлигын Эсрэг Олуулаа Нэгдье", "АВЛИГА-Хожихгүй нүүдэл", "Авлигын шилэн бөмбөлөг", "Гэрэл тусгая", "Ээжийн захиа", "Авлигын эсрэг олуулаа нэгдье", "Авлига, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ" зэрэг ТВ шторк, теле зохиомжийг газрын Угтах хэсэгт байршуулсан дэлгэцээр болон цахим хуудсаар олон нийтэд түгээн хүргэж ажиллав.</p>	-	100

				Авлигатай тэмцэх газраас гаргасан Соён гэгээрүүлэх аяны хүрээнд "Авлигыг мэдээл 110" – "Зөв зөвд Шударга зөв наалтыг байгууллагын 11 албан тасалгааны өрөөний үүдэнд байршуулсан.		
2	1.2. Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах;		- Дэмжиж хамтран ажилласан байх; - Салбар нэгж, орон нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх	Байгууллагын цахим хуудасны эхний нүүр хэсэгт Авлигатай тэмцэх газрын "110" тусгай дугаарын утсыг сурталчилсан постер болон тус газрын Олон нийтийн төв пэйж хуудасны QR кодыг байршуулж, нэгдэж ажиллав.	-	100
3	1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах;		- Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх; - Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх	2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Тамгын газраас ирүүлсэн авлигын эсрэг мэдээлэл бүхий "Шударга ёс, хөгжил дэвшилд" бүхий самбартай байх чиглэл ирүүлсний дагуу Газрын мэдээллийн самбарын загварыг шинэчлэн батлуулсан. Хэвлэлтээс хүлээгдэж байна.	700,000 төгрөг	90
Зорилго 2: Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах						
4	2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөөлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ- т хүргүүлсэн байх;		-Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Зөвлөмж хүргүүлэх тухай 2022 оны 05/9552 дугаартай албан бичгийн дагуу урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилт хангах чиглэлээр хамтран ажиллаж албан хаагчдад сургалт авах хүсэлтийг Газрын даргын 2022 оны 01/10/2906 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2023 онд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт авах саналыг заасан хугацаанд хүргүүлэн ажиллах болно.	-	70
5	2.2. АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан шатны сургалтад албан хаагчдаа хамруулсан байх;		-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	2022 онд шинээр томилогдсон албан хаагчдад болон 10 албан хаагчид ХАСХОМ хэрхэн гаргах талаар сургалт, мэдээллийг биечлэн танхимаар 2 удаа өгч, цахимаар байгууллагын дотоод сүлжээнд байршуулсан гарын авлага, заавартай танилцах мэдээллийг тухай бүр өгч ажиллав. З.У. KHOT BAIGUULALT, KHUGJLIIN GAZAR11. HUULI & DUREM JURAM18. XASUM & XASXOMGARIIN AVLAGA & TANILTSUULGA NICHEEL & ZUVLUMJ	-	100
6	2.3. АТГ-аас зохион байгуулдаг		-Сургалтад	Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн даргын	-	100

	авлигын эсрэг давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх;		хамрагдсан албан хаагчийн тоо	2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн баталсан хөтөлбөрийн дагуу "Ашиг сонирхлын зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх нь", "Мэдэгдэл, тайлбар гаргахад анхаарах асуудал", "Авлигын гэмт хэргийн хуульчлагдсан байдал" зэрэг сэдвээр онлайн сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулав. Сургалтад нийт 52 албан хаагч хамрагдав.		
7	2.4.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залуус хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байх;		-Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх; -Хамрагдсан хүүхэд залуус, иргэд тоо	2021 онд зохион байгуулагдсан Авлигын эсрэг үндэсний чуулганд оролцогч, илтгэгчдээс гаргасан зөвлөмжийг газрын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээж ажиллав.	-	-
Зорилго 3: Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх						
8	3.1 Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх		-Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх	Авлигатай тэмцэх газрын 2021 оны 01/14138 дугаартай албан бичиг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 03/798 дугаартай албан бичгээр тус тус ирүүлсэн Авлигын эсрэг үндэсний чуулганд оролцогч, илтгэгчдээс гаргасан зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулж ажиллав. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвшөөрөлгүй барилга угсралтын ажил эхлүүлсэн барилгын талаар хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай болон зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах тухай албан бичгийн дагуу 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дөрвөн заалт бүхий "Авлигатай тэмцэх газраас зөвшөөрөлгүй барилга, байгууламжийн талаар ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын хариу арга хэмжээний жилийн ажлын төлөвлөгөө" Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	-	100
9	3.2 Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх		-Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх	Авлигатай тэмцэх газраас 2022 онд нийт 44 албан бичиг ирүүлснээс мөрдөн шалгах ажиллагаанд шаардлагатай нотлох баримт гаргуулах тухай 29, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай 8 (17 албан хаагчийн), хууль	-	100

				<p>тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж ажиллах тухай болон зөвлөмж, мэдээлэл ирүүлсэн 5, журмын төсөлд ирүүлсэн санал, хэлэлцүүлэгт оролцох талаар 2 албан бичгийг тус тус ирүүлсэн байна.</p> <p>Авлига хүнд суртлыг таслан зогсоох арга хэмжээ авах, авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын дүгнэлтийн хариу арга хэмжээний жилийн ажлын төлөвлөгөөг 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Газрын даргаар батлуулж, биелэлтийн тооцож ажиллав. Төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээ, тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 10/2326 дугаартай албан бичгээр хүргүүлж ажиллав.</p> <p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвшөөрөлгүй барилга угсралтын ажил эхлүүлсэн барилгын талаар хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай болон зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах тухай албан бичгийн дагуу 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дөрвөн заалт бүхий "Авлигатай тэмцэх газраас зөвшөөрөлгүй барилга, байгууламжийн талаар ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын хариу арга хэмжээний жилийн ажлын төлөвлөгөө" Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах чиглэлээр Авлигатай тэмцэх газраас албан бичиг ирээгүй байна.</p>		
10	3.3.Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх		-Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх	<p>Авлигатай тэмцэх газрын Тамгын даргын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр баталсан "Авлигын эрсдэлийн үнэлгээний мөрөөр ажиллах удирдамж"-ийн дагуу тус газарт 2020 онд Газрын авлигын эрсдэлийн үнэлгээний тайланд ирүүлсэн "Зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах тухай" Авлигатай тэмцэх газрын 2020 оны 03/11485 дугаартай албан бичгийн дагуу эрсдэлийн үнэлгээний хэрэгжилтийн тайлан мэдээг 2022 оны байдлаар гарган Авлигатай тэмцэх газарт 01/3371, 3408 дугаартай албан бичгээр Зөвлөмжийн</p>	-	100

				хэрэгжилтийн тайлан, холбогдох баримтын хамтаар тайлагнаж ажиллав. Тайлант хугацаанд мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах чиглэлээр Авлигатай тэмцэх газраас албан бичиг ирээгүй байна.		
Зорилго 4: Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх						
11	4.1 Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал;	Санал, санаачилга уриа, аянд нэгдэж, тодорхой үр дүнд хүрсэн байх		<p>Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлж буй Соён гэгээрүүлэх аян, Өөрчлөлтийг хамтдаа аян, Зөв зөвд-Шударга зөв аяны хүрээнд "Авлигын эсрэг хамтдаа" таныг сонсож байна булан, "Авлигыг мэдээл 110", Олон нийтийн төв пэйж хуудасны QR кодыг цахимаар байршуулж, зурагт хуудас, боршур зэргийг албан хаагчдад болон иргэдэд нээлттэй танилцах боломжтой байдлаар хүргэж ажиллав.</p> <p>Иргэдээс болон байгууллагын албан хаагчдын дунд "Санал хүсэлтийн хайрцаг"-аар санал, зөвлөмж, гомдол талархал хүлээн авах 1 сарын аяныг 4 дүгээр сард зохион байгуулсан. Аяны хүрээнд иргэдээс ямар нэгэн санал, гомдол ирээгүй. Харин албан хаагчдаас давхардсан тоогоор 260 гаруй талархлын захидал, бэлэг ирүүлснийг тухайн бүр нэгж, албан хаагчдад хүргүүлж ажиллав.</p> <p>2021 оны 11 дүгээр сард Ёс зүйн зөвлөлөөс гаргасан Зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулж ажилласнаар албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт болон ажлын цаг ашиглалт сайжирсан.</p> <p>Газрын даргын 2022 оны "Ажил сайжруулах тухай" А/42 дугаар тушаалаар эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний мөрөөр ажил сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Нэгжийн дарга нарт болон нийт албан хаагчдад үүрэг өгч, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллав.</p> <p>Мөн "Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод байлгаж, иргэдээс талархал хүлээн авч ажиллах аян"-ны удирдамжийг 2022 оны 10 дугаар сарын 17-</p>	-	100

				ны өдөр батлуулан 12 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж байна. Аяныг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний байдлаар дүгнэхэд 5 нэгжийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 1-2 хоногоор, 2 нэгжийн албан бичгийн шийдвэрлэлт 1 хоногоор тус тус буурсан үр дүн гарсан. Мөн энэ хугацаанд иргэдээс албан хаагчийн нэр дээр ямар нэгэн гомдол ирээгүй болно.		
12	4.2.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;		Авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээний тоо	2022 онд хот байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой 14 гэрээ байгуулж, бүх гэрээнд Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх МЭДЭГДЭХ хуудсыг гаргуулан авав. Хот байгуулалтын гэрээ, түүний биелэлтийн явцын талаарх мэдээллийг газрын дотоод сүлжээнд тухай бүр байршуулж ажиллав.	-	100
Зорилго 5: Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах						
13	5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх/ цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/		- Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх	“Авлигын эсрэг үндэсний чуулган”-аас гаргасан Зөвлөмж 2.8. “Цахим засаглалыг хөгжүүлэх, e-mongolia цахим системээр үзүүлэх төрийн үйлчилгээний төрөл, тоо, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээ авахад нэн шаардлагатай тоон бичиг үсгийн чадвартай иргэнийг бэлтгэхэд онцгойлон анхаарах, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах, иргэд төрөөс үйлчилгээ авдаг жишгээс төр иргэддээ үйлчилгээ санал болгодог хэлбэрт шилжих” заалтын хүрээнд: Газраас үзүүлж буй нийт 22 үйлчилгээний 8 нэр төрлийн үйлчилгээг www.eservice.ulaanbaatar.mn , www.e-mongolia.mn цахимд бүрэн шилжүүлсэн. Үүнд: - Барилга барих хүсэлт, - Барилгын загвар зураг батлах, - Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, - Барилгад хаяг дугаар олгох, - Байр зүйн зураг, - Тэг тэнхлэгийн актыг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэх	-	100

				<ul style="list-style-type: none"> - Инженерийн шугам сүлжээний зурган мэдээллээр үйлчлэх - Архивын лавлагаа олгох үйлчилгээ. <p>"Барилга барих хүсэлт буюу архитектур төлөвлөлтийн даалгавар" авах үйлчилгээг E-Mongolia цахим системээр дамжуулан хэрхэн илгээх зааврыг танилцуулсан аудио бичлэг хийсэн.</p>		
Зорилго 6: Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах						
14	<p>6.1 - Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;</p> <ul style="list-style-type: none"> - Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах; 		<p>-Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх</p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн байгууллагын веб сайтад тавих шаардлага /MNS 6285:2017 стандарт/-ын дагуу байгууллагын цахим хуудсанд ил тод нээлттэй байх шаардлагатай газрын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн шинэчлэлтийг, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу шилэн дансны холбогдох мэдээллийг заасан хугацаанд байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулан ажиллав.</p> <p>https://shilendans.gov.mn/org/4309</p> <p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн мэдээллийн ил тод байдал болон үйл ажиллагааны ил тод байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа тогтмол байршуулж, тухай бүр нэмэлт өөрчлөлт, баяжилтыг хийж ажиллав.</p> <p>Байгууллагын http://uda.ub.gov.mn цахим хуудсанд 13 төрлийн 282 мэдээ мэдээллийг шинэчилсэн.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээ – 11 - Үйл ажиллагааны төлөвлөгөө – 13 - Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт – 9 - Санхүүгийн мэдээ – 18 - Мэргэжлийн зөвлөлийн хурлын мэдээ – 80 - Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон мэдээ – 20 		

				<ul style="list-style-type: none"> - Цаг үеийн мэдээ – 22 - Хүний нөөцийн мэдээ – 18 - Бүтэц, зохион байгуулалтын мэдээ – 12 - Бусад – 7 - Ирсэн, явсан бичгийн мэдээ – 22 - Үйлчилгээний бүрдүүлэх материал – 23 - Хууль эрх зүйн -272. <p>Газраас үзүүлж буй 22 нэр төрлийн төрийн үйлчилгээний бүрдүүлэх материал, үйлчилгээний хяналтын хуудасны өөрчлөлт, баяжилтыг тухай бүр хийн Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн Драгон, Дунжингарав, Мишээл, Оргил, төвийн үйлчилгээний ажилтнуудыг сургаж, дадлагажуулах, Баянгол, Баянхошуу төвийн үйлчилгээний ажилтнуудыг мэдээ мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулав.</p> <p>Газрын даргын үйл ажиллагаатай холбоотой гарсан тушаалын агуулга бүхий бүртгэл, 2022 онд шинээр ажилд томилогдсон 26 албан хаагчийн, ажлаас чөлөөлөгдсөн 27 албан хаагчийн мэдээллийг цахим хуудсанд байршуулав.</p> <p>Байгууллагын зарим үйлчилгээ e-mongolia.mn холбогдсон талаар мэдээлэл бэлтгэн байгууллагын www.uda.ub.gov.mn цахим хуудас болон facebook хуудсанд байршуулсан.</p> <p>Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны судалгааг 2022 оны 01/652, 01/01/3293, 01/01/3931, 01/1/4282 дугаартай албан бичгээр хүргүүлж, газрын цахим хуудсанд тухай бүр байршуулан нээлттэй мэдээлэв. /4 удаа/</p> <p>Ирсэн, явсан албан бичгийн шийдвэрлэлтийн болон өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн сарын тайланг тухай бүр байршуулан нээлттэй мэдээлэв. /сар бүрийн нийт 12 удаагийн 24 тайлан/</p>		
--	--	--	--	--	--	--

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
ТАЙЛАН ГАРГАСАН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Ч.БАДАМХАНД
Т.БУЯНЖАРГАЛ